



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 25

Номгон

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл нь 2024 онд Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Тус салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэр, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллав.

**1.1 Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байдал:**

Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, Төрийн албаны суурь өгөгдлийн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэх, Төрийн албан хаагчдын албаны цахим хэрэглээг сайжруулах, чадавхжуулах, бүтээлч санал санаачилгыг дэмжих зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгдүгээр хуралдаанаараа хэлэлцэн 4 зорилт 16 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, эхний хагас жилийн байдлаар 80 хувийн биелэлтэйгээр хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6.2, 5 дугаар зүйлийн 5.7-т заасан чиг үүргийн хүрээнд Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, төрийн байгууллагуудад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, хууль, тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор 20 сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллалаа. Төрийн албаны тухай хууль,





## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Нийтийн албанд хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зарим заалтын биелэлтийг хянаж, зөвлөн туслах ажлыг 15 сумын ЗДТГ-ыг хамруулан зохион байгууллалаа.

Төрийн албаны Зөвлөлөөс гаргасан 15 удаагийн үүрэг чиглэл өгөх, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичиг ирүүлснийг тухай бүрт шийдвэрлэн ажиллалаа.

Төрийн албаны тухай хууль тогтоомж бодлого, шийдвэрийн хүрээн дэх төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн баталгаа, сургалт хөгжил, ёс зүйн зөрчил, сахилга хариуцлага, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зэрэг асуудлаар давхардсан тоогоор нийтдээ 5000 гаруй төрийн албан хаагч, иргэдэд биечлэн, утсаар, албан бичгээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Төрийн албаны зөвлөл тус аймагт ажиллахтай холбогдуулан бэлтгэл ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллалаа.

Ажлын хэсэг орон нутгийн удирдлагуудтай уулзаж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалт, төрийн албаны шинэтгэлийн бодлогын хэрэгжилттэй танилцах, тулгамдаж буй асуудлуудын



талаар төрийн албан хаагчийн санал хүсэлт сонсох, Салбар зөвлөлийн дарга, гишүүдтэй уулзалт хийж үүрэг чиглэл өгч, Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй ажил, төрийн албан хаагчийн нөөц, томилгоо, цалин хөлс, нийгмийн баталгаа, хөдөөгийн сэргэлт сэдвээр илтгэл тавьж, Төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтоомж, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга, сургалт зохион байгуулсан.

Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох болон хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, ТАЗ-ийн 2023 оны 482 дугаар тогтоолын биелэлтийг тооцов.

Дээрх хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан 17 дугаар хуралдаанаар Төрийн албаны зөвлөлийн төлөвлөгөөт хяналт, шалгалт, зөвлөн



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

туслах ажлын хүрээнд Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд аймгуудад ажилласан ажлын хэсгийн тайланг хэлэлцсэн.



Хуралдааныг өргөтгөсөн байдлаар зохион байгуулж, дээрх аймгуудын Төрийн албаны зөвлөлийн аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарыг биечлэн, салбар зөвлөлийн дарга нарыг цахимаар оролцуулан хяналт, шалгалт тайлантай холбоотой мэдээлэл хийв.

Зөвлөлийн хуралдаанаас Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилт, төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаа, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулах чиглэлээр үүрэг даалгавар өгч, “Хяналт, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолыг аймаг тус бүрээр гаргалаа.



Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж шийдвэр гаргасан томилох эрх бүхий албан тушаалтнуудад зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгч, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр тогтов.

Тус хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 2024 оны 171 дүгээр тогтоол ТАЗ-өөс батлагдаж, салбар зөвлөл биелэлтэд хяналт тавьж ажиллав.



Салбар зөвлөлийн даргын санаачлагаар аймгийн 20 сумын ЗДТГ-ын дарга нарыг хамруулан ТАЗ-ийн холбогдох албан тушаалтнуудаар “Төрийн албан хаагчийн томилгооны зөрчил, анхаарах асуудал”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр сургалт, мэдээлэл хийлгэж, ТАЗ-ийн үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг Улаанбаатар хотод 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулж ажиллалаа.

Тус сургалтаар томилох эрх бүхий албан тушаалтнуудын гаргадаг нийтлэг алдаа зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, хуульд заасан үндэслэл журмыг зөв



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

хэрэглэх, хууль зөрчсөн томилгооны үр дагавар, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хуулийн зохицуулалтын талаар зөвлөгөө авч, мэдээлэл солилцов.



Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Хүний нөөцийн аудитын багийн бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” 136 дугаар тогтоолоор батлагдсан удирдамжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай” 59 дүгээр тогтоолоор батлагдсан

журмын 3.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг ажлын хүрээнд хүний нөөцийн аудит хийлээ.

Баянхонгор аймгийн ИТХ, Засаг даргын Тамгын газар, Баянхонгор сумын ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 17 байгууллагын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлого арга хэмжээний явц, үр дүнг тооцох талаарх шалгалтыг зохион байгуулахад холбогдох хууль дүрэм журмын хэрэгжилт хангалтгүй байлаа. Тус аудитын тайланг ТАЗ-д хүргүүлэн ажиллав.

Улсын хэмжээнд хийгдсэн “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого тогтолцооны үр нөлөө” сэдэвт хийсэн гүйцэтгэлийн аудитад 2013-2024 оны хагас жилийн байдлаар үйл ажиллагааг хамруулан шалгуулж 5 зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа.

### **1.2 Төрийн албан хаагчид ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлыг зохион байгуулах, энэ талаар үүрэг даалгавар, арга зүйн зөвлөгөө өгсөн байдал:**

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох хууль журам хэрэгжилтийг эрчимжүүлж хуульд заасны дагуу “Ёс зүйн дэд хороо”-г шинэчлэн байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллах талаар 20 сум, аймгийн засаг даргын дэргэдэх 23 агентлагийн хүрээнд салбар зөвлөлөөс зөвлөн туслах ажлыг хийж хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 181 төрийн байгууллагын 122 нь ёс зүйн дэд хороог байгуулан ажиллаж, байгууллагын дэргэдэх **Ёс зүйн дэд хорооны нийт 20**




# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

удаагийн сургалт, зөвлөгөө, мэдээллийг 3000 орчим төрийн албан хаагчдад өгч ажиллажээ.

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, ёс зүйн хэм хэмжээг сахиулах талаар байгууллагуудын Дотоод журам, Хамтын гэрээ, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээнд тусгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн 6 зөрчлийг тэмдэглэснээс, тус бүрд нь уучлал гуйх 3, сануулах шийтгэлийг 3 ногдуулжээ.

Албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлээгүй, ажлын сахилга, хариуцлага алдсан зэрэг шалтгаанаар 6 төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн жил болж байгаатай холбогдуулан Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчдад хандаж гаргасан мэдэгдэлийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 372 дугаар захирамжаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, нийтийн дэг журам аюулгүй байдлыг хангах тухай” захирамжийг баталж сум байгууллагын дарга нарт албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг бататгах, төрийн албан хаагчийн ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд таниулах, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сурталчлах зорилгоор “Мэргэжил бүхэн сайхан” мэдлэг, авхаалж,

сорих олон төрөлт тэмцээнийг зохион байгуулж аймгийн хэмжээний төрийн албан хаагчдыг уриалан, үр дүнг тооцон ажилласан.

Аймгийн ЗДТГ, Төрийн албаны салбар зөвлөл, Төрийн аудитын газар, Хууль, эрх зүйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Богд сумын ЗДТГ-тай хамтран "Эрх зүйн шинэчлэл ба хэрэгжилт" сургалт, "Архив, албан хэрэг хөтлөлтийн үзүүлэх



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ  
сургууль**-г Богд суманд 09 дүгээр сарын 27-нд зохион байгуулж, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Архив, бичиг хэргийн эрхлэгч нар оролцлоо.

Сургалтын хүрээнд Салбар зөвлөлийн дарга “Төрийн албан хаагчийн ёс зүй”, нарийн бичгийн дарга “Сул орон тоо нөхөхөд анхаарах асуудал” сэдвээр тус тус мэдээлэл хийж, сумдад гарч буй сул орон тоо, нөхөгдөхгүй байгаа шалтгаан нөхцөл, иргэний нөөц бүрдүүлэх арга зам гэх мэт асуудлаар харилцан ярилцав.



### **1.3 Салбар зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэрлэлт:**

Тус Салбар зөвлөл нь 2024 онд 13 удаагийн хуралдааныг хийж, эрх хэмжээний хүрээнд 41 асуудлыг хэлэлцэн 38 тогтоол шийдвэр гаргаж, хэрэгжилтийг 100 хувь зохион байгууллалаа.




Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд нийт 199 албан бичгийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, үүнээс орон нутгийн хэмжээнд Төрийн албаны тухай хууль, тогтоомж, төрийн албаны стандарт, Төрийн албаны зөвлөлөөс гаргаж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, ирсэн албан бичгийн шийдвэрлэлтийн хариуг хүргүүлэх чиглэлээр 161, аймгийн хэмжээнд төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлсэн 17, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариуг хүргүүлсэн 21 албан бичгийг тус тус гаргалаа.

Тайлант хугацаанд албан бичиг ирснээс хариутай 197 албан бичгийг 100 хувьтай шийдвэрлэж ажиллалаа.

Салбар зөвлөлд иргэдээс нийт 16 өргөдөл, гомдол ирүүлснийг хуралдаанаар хэлэлцэн 16 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариуг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. Өргөдөл гомдлыг 100 хувь шийдвэрлэж, өргөдөл гомдлын тоо урьд оны мөн үеэс 65 хуваир буурсан байна.



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**  
*Салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо:*



**Хоёр. Төрийн албаны нөөц бүрдүүлэх талаар:**


**2.1 Харьяалах байгууллагын “Хүний нөөцийн удирдлагын систем”-д мэдээлэл оруулж, төрийн байгууллагыг төрийн албан хаагчийн тоо бүртгэл хөтлөхөд мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан байдал:**

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх журам”-ын дагуу тус салбар зөвлөлд харьяалагдах 181 төрийн байгууллага дээрх системийг хөтлөн явуулдаг.

Төрийн албаны улсын нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх, хүний нөөцийн цахим системд мэдээлэл оруулах талаар нийт 120 гаруй төрийн байгууллагын давхардсан тоогоор 90 гаруй удирдах болон гүйцэтгэх албан хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн, [www.facebook.com /Баянхонгор Хүний нөөцийн асуудал](http://www.facebook.com/Баянхонгор_Хүний_нөөцийн_асуудал) хариуцсан ажилтны групп чат, ТАЗ-ийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл гэсэн удирдах ажилтнуудын групп чат/-аар тус тус мэдээллийг түгээн холбогдох асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

**Гурав. Төрийн албаны шалгалт зохион байгуулсан талаар:**

**3.1 Төрийн албаны Ерөнхий шалгалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байдал:**



Төрийн албаны ерөнхий нөөц бүрдүүлэх Төрийн албаны ерөнхий шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан журмын хүрээнд Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тов, чиглэлийн дагуу 4 удаа шалгалтыг зохион байгуулж, 107 иргэний ерөнхий нөөцийг бүрдүүллээ.



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**Төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг зохион тухай:**  
байгуулсан



Тус аймагт төрийн албаны ерөнхий шалгалтад орж, нөөцөд бүртгэгдэж буй иргэдийн тоо буурсан хэдий ч шалгалтын онооны үзүүлэлт өмнөх оны дүнтэй харьцуулахад өссөн нь аймгийн хэмжээнд төрийн албаны ерөнхий шалгалтын мэдээллийн хүртээмж сайжирч, иргэдийн мэдлэг, мэдээлэл болон шалгалтад бэлдэж оролцох хандлага өөрчлөгдсөнийг доорх чанарын үзүүлэлт харуулж байна.

**3.2 Төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийн байдал:**

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 4 удаагийн 17 сул орон тоог нөхөх шалгалтыг нийтэд зарлан, зохион байгуулж, 8 сул орон тоог нөхсөн.



Төрийн захиргааны байгууллагын удирдах, нэгжийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 9 удаагийн давхардсан тоогоор 189 сул орон тоог нөхөх тусгай



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

алгалтыг нийтэд зарлаж, 9 удаагийн шалгалтыг зохион байгуулж, 91 сул орон тоог нөхсөн.

**Төрийн албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулсан талаар:**



**Дөрөв. Сургалт, судалгаа, сурталчилгаа хийх талаар:**

Төрийн байгууллага Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т заасны дагуу төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2, 24, 29 дүгээр зүйл, 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтад төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 142 төрийн байгууллагын 85 нь буюу 60.2 хувь нь байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, эрх чөлөө, тусгаар тогтнолоо баталгаажуулан Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 100 жилийн ойг угтан Үндсэн хуулийн мэдлэгийг батжуулж, төрийн албан хаагчдын төлөөллөөр дамжуулан хууль дээдлэх ёсыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтаар 62 төрлийн видео шторк бэлтгэн иргэд олон нийтэд түгээн ажилласан.





**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**“Үндсэн хууль 100 жил” сэдэв бооцоот нөхөрсөг тэмцээнийг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулав.**

✦ Үндсэн хуулиа дээдлэн хүндэтгэх үзэл санааг иргэд, төрийн алба хаагчдад сурталчлан таниулах, хуулийг дээдлэн хүндэтгэх төрийн алба хаагчдын манлайллыг нэмэгдүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, чийрэгжүүлэх эрүүл амьдрах зөв дадал хэвшлийг бий болгох зорилгоор төрийн албан хаагчдын дунд нөхөрсөг гар бөмбөгийн тэмцээнийг 20 байгууллагын 300 гаруй төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан.



Үндсэн хуулийн 100 жилийн ойн хүрээнд **“Төрийн албан хаагчдадаа баярлалаа”** урлагийн арга хэмжээг зохион байгуулж 17 байгууллагын 500 гаруй төрийн албан хаагчид оролцсон.

Салбар зөвлөл Баянхонгор аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхтэй хамтран Захиргааны хэргийн шүүх байгуулгагдсаны 20 жилийг ойг угтан “Захиргааны шийдвэр боловсруулалт, хуулийн хэрэглээ” сэдвээр төрийн байгууллагын алба хаагчдад сургалт зохион байгууллаа.



Төрийн албаны тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч, иргэдэд сурталчлах зорилгоор тус салбар зөвлөлөөс видео, нэвтрүүлэг, постер зэргийг бэлтгэн Төрийн албаны зөвлөлийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл цахим групп, аймгийн [www.bayankhongor.gov.mn](http://www.bayankhongor.gov.mn) албан ёсны цахим

хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилж байна.

**Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлаар зохион байгуулсан ажил, үр дүн, түүний хэрэгжилтийн талаар:**



## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна.

Баянхонгор аймаг дахь салбар зөвлөлөөс Улсын Их Хурлын “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам” батлах тухай 21 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох болзол шаардлагыг хангасан төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгуулах саналыг аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлж ажиллалаа.

Болзол, шаардлагыг хангасан 120 төрийн жинхэнэ албан хаагчдын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох асуудлыг Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн, саналыг аймгийн Засаг даргад уламжилж, аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн.

Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг үндэслэн, Төрийн албаны тухай хуулийн 22, 27, 28, 31 дүгээр зүйлд тавигдсан шаардлага, нөхцөл болзлыг хангаж, төрийн албаны шалгалтад тэнцэн, тухайн албан тушаалд туршилтын хугацаанд ажиллахдаа төрийн албан хаагчийн зорилго, зорилт, чиг үүргээ мэргэжил ур чадварын зохих түвшинд амжилттай гүйцэтгэж байгаа нийт 8 албан хаагчийн “Төрийн албан хаагчийн тангараг” өргүүлэх ёслолын ажиллагааг “Төрийн албаны өдөр” буюу 7 дугаар сарын 03-ны өдөр, Анхдугаар Үндсэн хууль батлагдаж, Бүгд найрамдах улс тунхагласны 100 жилийн ойн хүрээнд 11 дүгээр сарын 26-ны өдөр тус тус зохион байгууллаа.

Тангараг өргөх ёслолын ажиллагаанд төрийн захиргааны 9 байгууллагын нийт 26 албан хаагчид төрийн албанд чин үнэнчээр зүтгэж, хуулийг дээдлэн ажиллахаар тангарагаа өргөлөө.





# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ


Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журамд заасан болзол, шаардлага хангасан төрийн захиргааны байгууллагад тасралтгүй олон жил үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан 5 албан хаагчийн материалыг хүлээн авч хэлэлцэн “Төрийн албаны Тэргүүний ажилтан” цол, тэмдэгээр шагнуулахаар уламжилсан.



МУ-ын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 205 дугаар тогтоолоор түүхэн үйл явдлын ой тэмдэглэлт өдрийн жагсаалтад “Төрийн албаны өдөр”-ийг жил бүрийн 7 дугаар сарын 03-ны өдөр байхаар тогтоосны дагуу Салбар зөвлөлөөс мэндчилгээ бэлтгэн ТАЗ-д хүргүүлэн ажиллав.

Төрийн албаны тухай хууль, холбогдон гарсан журам, дүрэм, салбар зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, хууль тогтоомжийн хүрээнд төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг аймгийн [www.bayankhongor.gov.mn](http://www.bayankhongor.gov.mn) цахим хуудас, [www.facebook.com/Баянхонгор](https://www.facebook.com/Баянхонгор) аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хаяг, салбар зөвлөлийн мэдээллийн самбарт байршуулан мэдээлэн ажиллаж байна.

ХЯНАСАН ДАРГА  Д.ЭНХЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Д.САРАНГАРАВ